



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/310

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Технологийн машинд суурилуулах шувуу үргээх дуу авианы төхөөрөмж 1 ширхэг (Өлгий) нийлүүлэх ИНҮТ/ХО/ХА/Б-29/21 дугаартай гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

С.Булганцэрэн

Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын албаны Аэродромын засвар арчлалтын хэсгийн дарга

Гишүүд

Э.Мөнх-Эрдэнэ

Нисэх буудлуудын бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтсийн аэродромын үйлдвэрлэл, үйлчилгээ, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Б.Нүүдэл

Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын албаны Аэродромын засвар арчлалтын хэсгийн ажилчин-шувуу үргээгч

Б.Оюунчимэг

Худалдан авах ажиллагааны тасгийн ахлах инженер

Х.Мянганжадамба

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нягтлан бодогч

2. Энэхүү гэрээгээр нийлүүлэгдэж байгаа бараа, үйлчилгээг гэрээнд заасан тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, 2021 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн дотор Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг ажил хүлээн авах комисс (С.Булганцэрэн)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ